

Техник технологийн албаны танилцуулга

Нийслэлийн “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 1-р баазын Техник технологийн алба нь

1. Автын засвар үйлчилгээ
2. Ерөнхий механикийн хэсэг 2 нэгж, 63 хүний бэрэлдэхүүнтэй ажиллаж

байна.

Нэг. Тоног төхөөрөмжийн талаар:

Нийт 150 автобусны техникийн үйлчилгээ, засварын ажлыг гүйцэтгэх засвар үйлчилгээний станц, кузов засварын цех, автобус угаалгын газар, тоног төхөөрөмжийн засварын хэсэг, I ба II граж гэсэн объектод үйл ажиллагаа явуулж байна.

Засвар үйлчилгээний станцад дугуйн цех, механик цех, мотор цех, агрегат угаалга, түлшний систем, цахилгаан систем, засвар үйлчилгээ хийх ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Тус станц нь 5 сувагтай суваг бүр өргүүртэй, 4 талбайтай 9 автобусанд зэрэг засвар үйлчилгээ хийж, техник оношлогооны иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон болно.

- Дугуйн цехэд дугуйг автоматаар задлаж, угсрах стэнд, халуун нөхөөс тавих хэсгээс бүрдэнэ.
- Механик цехэд хойд ба урд барабан зорох суурь машин, накладка ба диск хадах суурь машин, тосон шахуургатай шахагч машин, тахир гол өнгөлгөөний суурь машин, токарын суурь машин, босоо өрмийн суурь машин, дагуу өнгөлгөөний суурь машин, цахилгаан точиль, суурин таслагч зэрэг тоног төхөөрөмжөөр ажил үйлчилгээ явуулж байна.
- Моторын цех нь цахилгаан өргүүр бүхий таль, мотор зүгшрүүлэх стэнд бусад багаж төхөөрөмжүүдтэй. Тэжээлийн болон цахилгаан системийн гэмтэл илрүүлэх, шалган тохируулах стэндүүдтэй.
- Кузов засварын цех нь 5 автобусны багтаамжтай 2 суваг, 2 талбай, 1 автомат өргүүр, будгийн камер зэргээс бүрдэнэ.
- Автобус угаалгын газар нь нэгэн зэрэг 2 автобус угаах хүчин чадалтай автомат угаалгын төхөөрөмжтэй.
- Тус бүр 60 автобусны багтаамжтай 2 дулаан гражтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Хүний нөөцийн талаар:

Техник технологийн албаны Ахлах инженерээр Мэргэшсэн инженер Г.Баярмөнх, Ерөнхий механикаар Ш. Батсүх, ХАБЭААХАжилтан А. Сүхбаатар, засварын инженерээр Механик инженер Ч.Алтангэрэл, Н.Цэнд, мэдээлэл технологийн инженер О. Цасзолбоо, техникийн тоо бүртгэгчээр У. Сайханцэцэг, тэрэг тавигчаар Б. Ганбаатар, Г. Намгүр, С. Цогтсүмбэр, Д. Чимэддорж, Н. Мөнхбаяр, Д. Мөнхбаяр, Д. Наянжин, Ц. Төмөр-Очир, Д. Тугбаатар нар, шалгах механикаар Д. Цэрэнбаатар, Л. Болдбаатар, А. Даваасүрэн, А.Оймандах , Э. Оргил, Б. Сунхар, Нямдорж нарын инженер техникийн ажилтнууд ажиллаж байна.

Тоног төхөөрөмжийн засварчин-6

Үүнээс 6-р зэрэгтэй Д. Даваажав, Ч. Ганбаатар нар, 4-р зэрэгтэй Д. Нямсамбуу, 3-р зэрэгтэй Р. Отгонжаргал, Балдан-Очир, Батсүх нар ажиллаж байна.

Засвар үйлчилгээний станцад 31 автын засварчин

Инженерийн боловсролтой 3, дунд боловсролтой 8, МСҮТ төгссөн 6, курс төгссөн 15 засварчин ажиллаж байна.Үүнээс

- 6-р зэрэгтэй засварчид: Н. Ганзориг, О. Алгаа, Д. Ширзана, Н. Раднаабазар, П. Саруулгэрэл
- 5-р зэрэгтэй засварчид: Ш. Батсуурь, Р. Даваасүрэн, Ж. Батжаргал, Д. Батбаатар, До. Энхбат, Ж. Батсүрэн нар байгаа бол бусад засварчид 3, 4-р зэрэгтэй ажиллаж байна.

Үйл ажиллагааны талаар:

Тоног төхөөрөмжийн засварчид нь баазын цахилгаан, дулааны шугам сүлжээ, сантехникийн болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

Автын засварчид нь нийт хөдлөх бүрэлдэхүүнд техникийн 1 ба 2-р үйлчилгээ, их ба урсгал засварыг технологийн дагуу хийж, техникийн оношлогоог тухай бүр хийж гүйцэтгэх, зарим эд ангийг сэргээн засварлаж, фондлох, техникийн бэлэн байдлыг 90 хувиас дээш байлгах зорилтийг ханган ажилладаг.

ЗҮС-д тэрэг тавигч 4, 1 ба 2-р гражид шалгах механик, тэрэг тавигч тус бүр 5 хүн ажиллаж, хөдлөх бүрэлдэхүүнд хяналт тавин ажиллаж байна.

Техник технологийн алба нь мэргэжлийн засварчдаар хангагдсан



Автын засварын хэсэгт ерөнхий инженер-1, засварын инженер-3, засварчин-32

Ерөнхий механикийн хэсэг



Байгууллагын ус дулаан, цахилгаан зэрэг шугам сүлжээний болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.